



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 34 (607)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Үндэсний сурын харваачдад улсын цол олгох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай*
- *Тусгай зориулалтаар 2010 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны есдүгээр сарын 11 № 34 (607)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

460.	Үндэсний сурын харваачдад улсын цол олгох тухай	Дугаар 47	767
461.	Улсын начин цол олгох тухай	Дугаар 48	767
462.	Улсын харцага цол олгох тухай	Дугаар 49	768
463.	Улсын заан цол олгох тухай	Дугаар 50	768
464.	Улсын даян аварга цол олгох тухай	Дугаар 51	768

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

465.	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай	Дугаар 100	768
466.	Хөтөлбөр дэмжих тухай	Дугаар 110	769
467.	Тусгай зориулалтаар 2010 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай	Дугаар 112	769
468.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 113	769
469.	Ажлын байрны аттестатчиллын дүнгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 122	771
470.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 134	772
471.	Хамгаалалтын бус тогтоох тухай	Дугаар 135	772
472.	Дүрэм батлах тухай	Дугаар 138	773

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Үндэсний сурын харваачдад улсын цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.2 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 803 жилийн ой, Ардын хувьсгалын 88 жилийн ойн баярын Үндэсний сурын эрэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Баян-Өлгий аймгийн Буянт сумын уугуул, Зэвсэгт хүчний Алдар спорт хороо, 330 дугаар

анги, Жем интернейшл компанийн харваач Батаагийн Баярсайханд "Монгол Улсын мэргэн" цол, эмэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Төв аймгийн Баян-Өнжүүл сумын уугуул, Ерөө импекс, Гео транс компанийн харваач, спортын мастер Гийнаагийн Батзаяад "Монгол Улсын мэргэн" цол тус тус олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Улсын начин цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 803 жилийн ой, Ардын хувьсгалын 88 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 5 давсан дараахь бөхчүүдэд "Улсын начин" цол олгосугай.

1. Эрдэнэбилгийн Энхбат - Булган аймгийн Могод сумын харъяат, "Хангарьд" клуб, Батлан Хамгаалах Их Сургуулийн бөх

2. Сүхбаатарын Мөнхбат - Увс аймгийн Баруунтуруун сумын харъяат, "Уурхайчин" клуб, Хилийн цэргийн 0311 дүгээр ангийн бөх

3. Нямаагийн Батзаяа - Ховд аймгийн Булган сумын уугуул, Чандмань сумын харъяат, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн бөх

4. Цэдэвийн Содномдорж - Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын уугуул, "Хилчин" спорт хороо, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн бөх

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

УЛСЫН ХАРЦАГА ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Их Монгол улс байгуулагдсаны 803 жилийн ой, Ардын хувьсгалын 88 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 6 давсан дараахь бөхчүүдэд "Улсын харцага" цол олгосугай.

1. Өлзийтогтохын Бат-Орших - Увс аймгийн Улаангом сумын харъяат, Батлан Хамгаалах Их Сургууль, "Хөх" сүлд клубийн бөх

2. Даш-Очирын Батболд - Баянхонгор аймгийн Баянбулаг сумын харъяат, Онцгой байдлын Ерөнхий газрын аврах тусгай ангийн бөх

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

УЛСЫН ЗААН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 803 жилийн ой, Ардын хувьсгалын 88 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 7 давсан

Булган аймгийн Бүрэгхангай сумын харъяат, Хилчин спорт хороо, Хилийн цэргийн 0253 дугаар анги, "Жигүүр гранд" группийн бөх Мөнхсайханы Өсөхбаярт "Улсын заан" цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

УЛСЫН ДАЯН АВАРГА ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 803 жилийн ой, Ардын хувьсгалын 88

жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 9 давж түрүүлсэн Архангай аймгийн Батцэнгэл сумын харъяат, Алдар спорт хороо, "Бридж" группийн бөх Гэлэгжамцан Өсөхбаярт "Улсын даян аварга" цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай

Газрын тухай хуулийн 18.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дорнод аймгийн Чойбалсан сумын нутаг дэвсгэрт 124.4 мянган га газрыг аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар тусгай хэрэгцээнд авч,

отрын бэлчээрийн хилийн заагийг хавсралтын ёсоор тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД

Т.БАДАМЖУНАЙ



Засгийн газрын 2009 оны 100 дугаар тогтоолын хавсралт

АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭРИЙН ХИЛИЙН ЗААГ

Дорнод аймгийн Чойбалсан сум дахь аймаг дундын отрын бэлчээрийн хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицрт:

Эргэлтийн цэгийн дугаар	Газрын нэр, тоот өндөрлөг	Солбицол	
		Уртраг	Өргөрөг
1	Халзан толгой	115° 28' 30.5"	49° 03' 39.6"
2	Сүүжүү ухаа	115° 30' 17.3"	49° 04' 34.4"
3	788 тоот өндөрлөг	115° 31' 17.3"	49° 07' 08.5"
4	Дунд хярт уул	115° 41' 38.8"	49° 20' 36.4"
5	655 тоот өндөрлөг	115° 59' 21.3"	49° 30' 32.3"
6	Жирмийн бор овоо	116° 02' 24.8"	49° 27' 59.3"
7	Цагаан чулуут	116° 02' 58.7"	49° 12' 45.1"
8	Зүүн караат	116° 00' 23.9"	49° 11' 48.8"
9	Баян-Уул	115° 36' 48.9"	48° 58' 18.6"

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Дугаар 110

Улаанбаатар хот

2009 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр

Хөтөлбөр дэмжих тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ (Stand-by) хөтөлбөр-ийг дэмжсүгэй.

нь:

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын валютын сангийн хооронд байгуулсан "Стэнд бай

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Дугаар 112

Улаанбаатар хот

2009 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Тусгай зориулалтаар 2010 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай

Ан агнуурын тухай хуулийн 8.3, Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2010 онд тусгай зориулалтаар угалз 50, тэх 200, бор гөрөөс 50, цагаан зээр 80, саарал чоно 60 толгой, агнуурын шувуу 200 хүртэл толгой агнуулахаар, гадаад оронд амьдаар гаргах идлэг шонхор шувуу 240 толгой байхаар тус тус тогтоосугай.

2. Амьдаар барих нэг толгой идлэг шонхор шувууны жишиг үнийг 12000 ам.доллар, төлбөрийг 10800 ам.доллар, хураамжийг 960 ам.доллар байхаар тогтоосугай.

3. Тогтоолын 1 дүгээр зүйлд заасан ан

амьтныг тусгай зориулалтаар агнаж, барьсан зөвшөөрлийн хураамжийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод тооцож, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Олон улсын ангийн үзэсгэлэн худалдаанд Монгол Улсаас угалз, тэх зэрэг агнуурын зарим ховор ан амьтан агнах эрхийг дуудлага худалдаанд оруулах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Л.ГАНСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Дугаар 113

Улаанбаатар хот

2009 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Улсын Их Хурлын 2005 оны 25 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Мянган хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 53 дугаар тогтоолын 4, 6 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"4. Мянган хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон бодлогын арга хэмжээний төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжүүлэлт, хяналт-шинжилгээний үйл ажиллагааг энэхүү тогтоолын хавсралтад тусгагдсан ажил үүргийн хуваарийн дагуу нягт уялдаатай зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

6. Улсын Их Хурлаас өгсөн үүргийн дагуу Мянган хөгжлийн зорилтын хэрэгжилтийн явц байдлын тайланг 2007 оноос эхлэн хоёр жил тутамд нэг удаа бэлтгэн гаргаж, тухайн жилийн 8 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулан Улсын Их Хуралд тайлагнаж байхыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун)-нд үүрэг болгосугай."

2. Засгийн газрын 2006 оны 53 дугаар тогтоолоор баталсан "Мянган хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан ажиллах байгууллагууд"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ


 Засгийн газрын 2009 оны 113 дугаар
тогтоолын хавсралт

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУД

Зорилго	Зорилт	Үндсэн хариуцах эзэн	Хамтарч хэрэгжүүлэх байгууллага
Зорилго 1. Ядуураал, өвслөгөн бууруулах	Зорилт 1. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах	НХХЯ, ХХААХҮЯ, ҮХШХ, СЯ	БСШУЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
	Зорилт 2. Хоол, тэжээлийн дутагдалтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 6 дахин бууруулах	ХХААХҮЯ	ЭМЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
	Зорилт 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж байгаа залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах	НХХЯ	ЗТБХБЯ, СЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
	Зорилт 4. Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч байгаа сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах	НХХЯ, ХЗДХЯ, ЭМЯ, БСШУЯ	ЗТБХБЯ, БОАЖЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
Зорилго 2. Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших	Зорилт 5. 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох	БСШУЯ	СЯ, ЭБЭХЯ, ЗТБХБЯ, ЭМЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
	Зорилт 6. 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагсдын хүйсийн зохистой харьцааг хангах	БСШУЯ	Төрийн албаны зөвлөл, НХХЯ, ХЗДХЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хороо, ТББ
Зорилго 3. Жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Зорилт 7. Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жендэрийн тэгш байдлыг хангах	НХХЯ	Төрийн албаны зөвлөл, ХЗДХЯ, ЭМЯ, БСШУЯ, ҮХШХ, аймаг, нийслэлийн ЗДТГ, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хороо, ТББ
	Зорилт 8. Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	НХХЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	Төрийн албаны зөвлөл, ХЗДХЯ, ЭМЯ, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хороо, ТББ
Зорилго 4. Хүүхдийн эндэгдлийг бууруулах	Зорилт 9. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах	ЭМЯ	СЯ, НХХЯ, ЭБЭХЯ, ЗТБХБЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
	Зорилт 10. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах	ЭМЯ	СЯ, ЭБЭХЯ, ЗТБХБЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
Зорилго 5. Эхмүүдийн эрүүл мэндийг сайжруулах	Зорилт 11. 2015 он гэхэд Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), Дархлалын олдмол хомсдол (ДОХ) өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх	ЭМЯ	НХХЯ, БСШУЯ, ХЗДХЯ, БОАЖЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
	Зорилт 12. 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах	ЭМЯ	НХХЯ, БСШУЯ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
	Зорилт 13. Хүүхдийн шүд цорох өвчний тархалтыг бууруулах	ЭМЯ	НХХЯ, БСШУЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
Зорилго 6. Бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ, ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах	Зорилт 14. Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх	БОАЖЯ	ЭБЭХЯ, ЗТБХБЯ, СХЗГ, ЭМЯ, СЯ, БХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
	Зорилт 15. Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах	БОАЖЯ	ЗТБХБЯ, ХХААХҮЯ, ЭБЭХЯ, БХЯ, СХЗГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
	Зорилт 16. 2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах	ЗТБХБЯ	БОАЖЯ, ЭМЯ, Усны ХЗГ, СЯ, СХЗГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
Зорилго 7. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах	Зорилт 17. 2015 он гэхэд хүн амын орон сууцны	ЗТБХБЯ	СЯ, ЭМЯ, БХЯ, СХЗГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ



Зорилго 8. Хөгжлийн төсөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх	Зорилт 18. Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянган хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх	СЯ, ГХЯ	ЗЭЗХЯ, ТББ
	Зорилт 19. Далайд гарцгүй Монгол Улсын онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан илүү тааламжтай нөхцөлөөр далайд, гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх	ЗТБХБЯ	ГХЯ, БОАЖЯ, ТББ
	Зорилт 20. Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндэр учруулахгүйгээр өрийг зохицуулах; шийдвэрлэж байх	СЯ	Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо
	Зорилт 21. Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, "Мэдээлэлжсэн нийгэм" байгуулах	МШХХТГ	ХЗДХЯ, ТББ
Зорилго 9. Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх	Зорилт 22. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахиж, хэвлэл, мэдээллийн эрх чөлөөл хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох	ЗГХЭГ	ХЗДХЯ, ГХЯ, НХХЯ, УСХ, Хүний эрхийн үндэсний комисс, МШХХТГ, ТББ
	Зорилт 23. Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх	Шадар сайд	ЗГХЭГ, ХЗДХЯ, ГХЯ, УСХ, ТББ
	Зорилт 24. Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэрхүүлэх	ЗГХЭГ, Авлигатай тэмцэх газар	ХЗДХЯ, УСХ, МУХАЙТ, ТББ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Ажлын байрны аттестатчиллын дүнгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангасан ажлын байраар хангах, үйлдвэрлэлийн орчныг сайжруулахад чиглэгдсэн тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдлыг бууруулах талаар тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжүүлэх зорилгоор хийсэн ажлын байрны аттестатчиллын дүнгийн мөрөөр дараахь арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ц.Шийрэвдамба нарт үүрэг болгосугай:

1.1. аттестатчиллаар хангалтгүй дүн үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад илэрсэн зөрчлийг арилгуулах, аттестатчилалд хамрагдаагүй уул уурхай, барилгын салбарын зарим аж ахуйн нэгж, байгууллагад үзлэг шалгалт явуулах;

1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, хөдөлмөрийн нөхцөлийн стандартыг хангуулах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хяналтыг эрчимжүүлэх;

1.3. Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвийн материаллаг баазыг бэхжүүлж, мэргэжлийн боловсон хүчний бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.

2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи анхан шатны мэдлэгийг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангиас эхлэн шат дараатай олгодог тогтолцоо бий болгох асуудлыг судалж шийдвэрлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаярт даалгасугай.

3. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн

тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай:

3.1. аттестатчилалд амжилттай сайн дүн үзүүлсэн байгууллага, намт олны туршлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи шинэ санаачилга, ажлын зөв эхлэлийг нийтийн хүртээл болгох;

3.2. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн түншлэлийн талууд, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах;

3.3. аймгийн төвийн байгууллага, орон сууцны халаалтыг нэгдсэн системд шат дараатайгаар оруулах, нам даралтын зуухны тоог цөөрүүлэх, тэдгээрт ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах;

3.4. зураг төсөл нь хянагдаагүй, хортой бус, зөвшөөрөлгүй газарт барилга байгууламж шинээр барих явдлыг таслан зогсоох, нэг хүнд ногдох ажлын байрны талбайн хэмжээ, барилга байгууламжийн чанар, стандартын хэрэгжлэлтэд орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагаас тавих хяналтыг сайжруулах;

3.5. нийслэлийн дүүргүүд болон Дархан-Уул, Орхон аймагт агааржуулалт хангалтгүй, байгалийн гэрэлтүүлэг хүрэлцээгүй, чийглэг ихтэй орон сууцны хонгилд ажил, үйлчилгээ явуулж байгаа байдалд хяналт тавьж, тэнд ажиллагсдын тоог бууруулах арга хэмжээ авах.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**
Т.ГАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5, Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 135 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх онц чухал объектын жагсаалт"-ын Нэг дэх хэсэгт "11. Дархан хотын ус хангамжийн эх үүсвэр" гэж нэмсүгэй.

2. Мөн хавсралтын Хоёр дахь хэсгийн 1 дэх заалтаас "Дархан" гэснийг хассугай.

3. Дархан хотын ус хангамжийн эх үүсвэрийг

дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад шилжүүлсэнтэй холбогдуулан уг объектын хамгаалалтын зардалд шаардагдах хөрөнгийг 2010 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд С.Баярцогт нарт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Хамгаалалтын бүс тогтоох тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт орших Эргэлийн зоон палеонтологийн дурсгалт газар, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт орших Өнгөтийн цогцолбор дурсгал, Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрт орших Их Хөшөөтийн цогцолбор дурсгал, Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг дэвсгэрт орших Өглөгчийн хэрэм, Рашаан хад, Үзүүр цохионы цогцолбор дурсгал, мөн аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг дэвсгэрт орших Балдан Бэрээвэн хийд, түүний орчмын хадны зургийн дурсгал, Дунд Жаргалантын цогцолбор дурсгал, Хэрлэн сумын нутаг дэвсгэрт орших Цэцэн ханы орды цогцолбор, Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт орших "Өндөр хоршоо" хэмээх түүхт барилга (Дүрслэх урлагийн музей), Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт орших Ардын Намын Төв Хороо, Ардын Засгийн газар түр байрлаж байсан түүхт барилгын (Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музей) хамгаалалтын бүсийг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хамгаалалтын бүсэд барилга байгууламж шинээр барих, хохирол учруулахууц үйл ажиллагаа явуулахыг зогсоож, бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор хамгаалалтын бүсэд шон тэмдэг тавих, хашаа барих зэрэг хамгаалалтын дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дээрх аймгийн болон нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын тогтоолоор баталсан нийслэлийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүсэд иргэн, аж ахуйн нэгжид газар олгосон байдлыг судалж, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, гаргасан захирамжийг хүчингүй болгох, цаашид түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүсэд газар олгохыг таслан зогсоох арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаярт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ё.ОТГОНБАЯР

Засгийн газрын 2009 оны 135 дугаар тогтоолын хавсралт

ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ХИЛИЙН ЦЭГҮҮД (СОЛБИЦЛЫН ЖАГСААЛТ)

№	Байршил	Цэгийн дугаар	Газар зүйн солбицол	
			Уртрагийн (X)	Өргөргийн (Y)
1	Дорноговь аймгийн Хатанбулаг сум, Эргэлийн зоон палеонтологийн дурсгалт газар	1	108°39'20"	43°21'55"
		2	108°44'35"	43°20'40"
		3	108°49'40"	43°20'50"
		4	108°51'12"	43°21'50"
		5	108°56'10"	43°21'10"
		6	109°00'55"	43°21'35"
		7	109°02'00"	43°21'28"
		8	109°12'05"	43°20'50"
		9	109°16'35"	43°17'40"
		10	109°11'28"	43°13'30"
		11	109°12'05"	43°15'20"
		12	109°02'10"	43°14'45"

		13	108°52'00"	43°14'24"
		14	108°45'30"	43°14'30"
		15	108°41'05"	43°16'19"
		16	108°36'05"	43°16'15"
		17	108°35'39"	43°19'25"
2	Төв аймгийн Алтанбулаг сум, Онгогийн цогцолбор дурсгал	1	105°50'52.86"	47°33'5.84"
		2	105°50'56.1"	47°33'16.28"
		3	105°51'7.47"	47°33'14.85"
		4	105°51'4.23"	47°33'4.22"
3	Төв аймгийн Дэлгэрхаан сум, Их Хөндвийн цогцолбор дурсгал	1	104°33'40.99"	46°55'4.2"
		2	104°33'39.58"	46°55'9.29"
		3	104°33'57"	46°55'11"
		4	104°33'58.7"	46°55'5.99"
4	Хэнтий аймгийн Батширээт сум, Өглөгчийн хэрэм, Рашаан хад, Үзүүр цохионы цогцолбор дурсгал	1	110°12'40"	48°27'28"
		2	110°19'47"	48°24'54"
		3	110°23'12"	48°23'33"
		4	110°20'55"	48°19'108"
		5	110°18'33"	48°20'35"
		6	110°10'30"	48°23'24"
		7	110°09'45"	48°25'40"
5	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум, Балдан Бэрэвэн хийд, түүний орчмын хадны зургийн дурсгал	1(A)	109°25'00"	48°12'42.5"
		2	109°25'56"	48°12'10"
		3	109°25'30"	48°11'50"
		4	109°25'00"	48°11'53"
		5	109°24'50"	48°12'32"
		1(B)	109°26'20"	48°11'52"
		2	109°31'00"	48°11'52"
		3	109°31'00"	48°11'45"
6	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум, Дунд Жаргалантын цогцолбор дурсгал	1	109°26'20"	48°11'45"
		2	109°30'29"	48°12'11"
		3	109°35'38"	48°13'37"
		4	109°38'45"	48°11'40"
		5	109°36'43"	48°09'45"
7	Хэнтий аймгийн Хэрлэн сум, Цэцэн ханы ордны цогцолбор (орон нутгийн музей)	1	5243166.061	474538.907
		2	5243166.061	474538.907
		3	5243166.061	474538.907
		4	5243118.810	474547.081
		5	5243105.133	474549.489
		6	5243101.841	474535.378
		7	5243094.374	474505.994
		8	5243087.510	474507.648
		9	5243084.799	474495.452
		10	5243080.476	474473.383
		11	5243147.217	474459.646
		12	5243156.455	474497.081
		13	5243157.503	474501.862
		14	5243157.917	474503.753
		15	5243166.061	474538.907
8	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, "Өндөр хорио" км-ээх түүхт барилга (Дүрслэх урлагийн музей)	1	5311354.95	642682.94
		2	5311325.83	642695.53
		3	5311327.87	642707.62
		4	5311341.22	642720.34
		5	5311341.66	642724.41
		6	5311342.17	642727.73
		7	5311337.63	642733.34
		8	5311338.97	642745.65
		9	5311339.61	642751.74
		10	5311339.87	642755.19
		11	5311302.09	642760.41
		12	5311300.70	642760.59
		13	5311293.11	642690.75
		14	5311294.25	642689.77
9	Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Ардын Намын Төв Хороо, Ардын засаг түр байрлаж байсан түүхт барилга (Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музей)	1	5311130.17	644690.79
		2	5311170.39	644687.55
		3	5311173.97	644722.82
		4	5311136.20	644724.79
		5	5311134.93	644720.22
		6	5311134.21	644713.55
		7	5311135.47	644707.68
		8	5311129.30	644706.37

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4^т дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цөмийн болон цацрагийн улсын хяналтын албаны дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2003 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 37 дугаар тогтоолын

хавсралтаар баталсан "Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм"-ийн 2.9 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ДОЛГОР

Засгийн газрын 2009 оны 138 дугаар
тогтоолын хавсралт

ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цөмийн болон цацрагийн улсын хяналтын зорилт нь цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хангуулах, цөмийн болон цацрагийн осол, цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн бусад үүсгүүрийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2. Цөмийн болон цацрагийн улсын хяналтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт Цөмийн энергийн газар болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид "улсын байцаагч" гэх) хэрэгжүүлнэ.

1.3. Цөмийн энергийн газар нь Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад цөмийн болон цацрагийн улсын хяналтыг зохион байгуулна.

1.4. Цөмийн энергийн газар, улсын байцаагч нь үйл ажиллагаандаа энэ дүрэм болон Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль, Аюултай хог, хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль, Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль, Захиргааны харилцдагын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.5. Цөмийн энергийн газрын харьяанд эмнэлэг, мэргэжлийн шарлагын хяналтын чиглэлээр төрөлжсөн лаборатори байна.

Хоёр. Цөмийн болон цацрагийн улсын хяналт

2.1. Цөмийн болон цацрагийн улсын хяналтыг дараах чиглэлээр зохион байгуулна:

2.1.1. цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт болон олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг шалган, хяналт тавих;

2.1.2. цөмийн болон цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, гарсан шалтгааныг тогтоох, учирсан хор уршгийг арилгуулах, цацрагийн ослын үед ажиллах журам, авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

2.1.3. цөмийн материал, үйлдвэрлэл, судалгаа, оношилгоо, эмчилгээнд хэрэглэж байгаа цацрагийн үүсгүүр бүхий благаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих;

2.1.4. цөмийн материалын тоо бүртгэл, цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтөлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

2.1.5. мэргэжлийн шарлагын тунг хянах,

мэргэжлийн шарлагын стандартын шаардлагыг хэрэгжүүлэх;

2.1.6. улсын хилээр нэвтрүүлэх цөмийн тусгай материал болон цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд цацрагийн хяналт тавих цацрагийн аюулгүй байдлыг хангуулах;

2.1.7. байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээний орчны цацрагийн хяналтын цэг, сүлжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

2.1.8. хүрээлэн байгаа орчны болон ахуйн өргөн хэрэглээний бараа, материал, хүнсний бүтээгдэхүүн, ундны ус, барилгын материалын цацрагийн түвшинд хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;

2.1.9. цацрагийн үүсгүүр хэрэглэгч байгууллага, аж ахуйн нэгжийн цацрагийн хяналтын ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, шаардлагатай асуудлаар санал боловсруулж шийдвэрлүүлэх;

2.1.10. цөмийн болон цацрагийн аюулгүйн стандарт, тэдгээрийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дүрэм, журам, зааврыг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих.

Гурав. Улсын байцаагчийн бүрэн эрх

3.1. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 7.3-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн болон цацрагийн осол, бохирдол бий болсон үед шаардлагатай бол хилийн боомт, аймаг, нийслэл, сум, дүүрэгт иргэдийн зорчих хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох, тээврийн хэрэгслийн ахад аюулгүй саатуулах болон бусад арга хэмжээг авах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад бүрэн эрхийнхээ хүрээнд тодорхой асуудал тавьж шийдвэрлүүлэх.

Дөрөв. Бусад

4.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь цөмийн болон цацрагийн улсын хяналттай холбоотой гомдлоо дараах үндэслэлээр эрх бүхий албан тушаалтан, улсын ерөнхий байцаагчид гаргана:

4.1.1. хяналт, шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдөн;

4.1.2. улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гаж үзсэн.

4.2. Гомдлыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхт зүйн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын

Хялхыг хэсэг хэвлэв.